



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 110

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах, бүртгэлд тусгах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 6.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хууль зүй, дотоод хэргийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 248,500,000.00 (хоёр зуун дөчин найман сая таван зуун мянган) төгрөгийн балансын үнэ, 72,479,166.55 (далан хоёр сая дөрвөн зуун далан есөн мянга нэг зуун жаран зургаан төгрөг тавин таван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг төрийн өмчийн данс бүртгэлээс хасч, хавсралтад заасны дагуу Дорнод аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг Цагдаагийн ерөнхий газрын дарга, хошууч генерал Ж.Болд болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хавсралтад заасан хөрөнгийг орон нутгийн өмчит Дорнод аймаг дахь Цагдаагийн газарт эзэмшүүлэх, данс бүртгэлд тусгах, ажлыг зохион байгуулах;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2022 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн "Үндсэн хөрөнгө данснаас хасах, бүртгэлд тусгах зөвшөөрөл олгох" 74 дүгээр тогтоолын хавсралтын "Хоёр.Автобааз, 2.1 Автотээврийн хэрэгсэл, Автомашин (Тоёота ландкрузер-200, 02-00 УАР), 2019.12.31, 172,800,000.00, ширхэг, 1.00, 172,600,000.00, 57,533,333.28, 115,066,666.72, Дорнод аймаг дахь Цагдаагийн газар" гэснийг хүчингүй болсонд тооцсугай.

132002326

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2022 оны 01 дугаар сарын 14-ны өдрийн
 210 дугаар тогтоолын хавсралт



ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ДАНСНААС ХАСАХ,
 ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГӨ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Хүлээн авах байгууллагын нэр
1	Автомашин (Тоёота ландркрийзер Л200, 01-35 УНУ)	2018.12.31	248,500,000.00	ширхэг	1	248,500,000.00	72,479,166.55	176,020,833.45	Дорнод аймаг дахь Цагдаагийн газар
	Нийт дүн					248,500,000.00 (хоёр зуун дөчин найман сая таван зуун мянган)	72,479,166.55 (далан хоёр сая дөрвөн зуун далан есөн мянга нэг зуун жаран зургаан төгрөг тавин таван мөнгө)	176,020,833.45 (нэг зуун далан зургаан сая хорин мянга найман зуун гучин гурван төгрөг дөчин таван мөнгө)	